

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/69

Номгон

Сумдын хөгжлийн индексийг тооцоолох  
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, “г” дэх заалт, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын хөгжлийн индексийг сум бүрээр тооцоолох ажлын хэсгийг 1-р хавсралтаар, Хөдөө орон нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санд бүртгэх ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар байгуулсугай.

2.Сумдын хөгжлийн индексийг сум бүрээр тооцоолох, Хөдөө орон нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санд бүртгэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг үнэн бодитой, шуурхай гаргаж ажиллахыг холбогдох газар, хэлтэс, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажлын тайланг хагас, бүтэн жилээр танилцуулахыг ажлын хэсэг /Т.Хишигбаатар/-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210175

Аймгийн Засаг даргын 2021 оны 01  
дүгээр сарын 27-ны өдрийн А/69  
дүгээр захирамжийн 1 дүгээр  
Хавсралт

**ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙГ СУМ БҮРЭЭР  
ТООЦООЛОХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар - Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга О.Эрдэнэ-Оюун – Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: С.Рэнцэндагва - Татварын хэлтсийн дарга

Д.Мөнхбат – Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Б.Жамьяндорж - Санхүү төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн


Х.Ганзориг - Статистикийн хэлтсийн дарга

Н.Одончимэг - Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Сумдын Засаг дарга нар

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2021 оны 01  
дүгээр сарын 27 ны өдрийн А/69  
дүгээр захирамжийн 2 дугаар



**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР  
ЭРХЛЭГЧДИЙГ АЖ ҮЙЛДВЭРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН  
САНД БҮРТГЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Б.Биндэръяа - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Х.Ганзориг- Статистикийн хэлтсийн дарга

Ж.Баттөр – Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Т.Саранчимэг - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Ууганцэцэг – Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн төслийн ахлах менежер

Сумдын Засаг дарга нар

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_